



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар

A/84

Жаргалтхаан

**Гэрээ байгуулж, санхүүжилтийн
эрх олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт нэн ховор ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах ажлын гэрээг О.Баясгалантай байгуулж, 1,390,000 (нэг сая гурван зуун ерэн мянган) төгрөгийн санхүүжилтийн эрх олгосугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1,390,000 (нэг сая гурван зуун ерэн мянган) төгрөгийг сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, Нягтлан бодогч Э.Загдхүү нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЦЭНГЭЛ



Data (D:) /A4 zahiramj/

232401197